



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2020.04.14 № 03/686
танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ДАШЦЭРЭН ТАНАА

Н/б дарга. Аюулгүй байдал-8.

*Сум газар албан
бичиг хүргүүлнэ*
[Signature] IV/21

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын “Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон. Уг албан тушаалын тодорхойлолтыг хэрэгжүүлэх явцад зарим сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс гомдол гаргажээ.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 11 дүгээр хуралдаанаар гомдлын нийтлэг асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргасныг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийг сумдын Засаг даргын Тамгын газар, албан тушаалтнуудад хүргүүлж, утга агуулгыг тайлбарлан таниулж, дахин гомдол, санал гаргахгүйгээр хэрэгжүүлж, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллана уу.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА



**СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ
ХЭРЭГЛЭХ ТУХАЙ**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолоор сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон.

Албан тушаалын тодорхойлолтыг баталж хэрэгжүүлэх явцад зарим аймгийн сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс гомдол ирүүлснийг Төрийн албаны зөвлөл 2020 оны 11 дүгээр хуралдаанаараа хэлэлцээд дараах тайлбар, зөвлөмж гаргасан. Үүнд:

Нэг. Албан тушаалын нэршил, ангилал, зэрэглэлийн тухай;

1/ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад **“Сумын байгаль орчны хяналтын Улсын байцаагч”** гэсэн нэршил бүхий албан тушаал тусгагдаагүй. Энэ нь албан бус нэршил болох тул Төрийн албаны зөвлөл уг албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл өгөөгүй.

2/ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолд “Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн” туслах түшмэлийн ангилал, ТЗ-3 зэрэглэлийн албан тушаал байхаар заасан ба сумын Засаг даргын Тамгын газрын **“Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн”** нь дээрх ангилал, зэрэглэлд багтана. Өөрөөр хэлбэл, сумын Тамгын газрын бүтэц, орон тоонд багтаж, Тамгын газрын дарга томилж, чөлөөлдөг албан тушаалтан болно.

3/ Мэргэжлийн хяналтын чиг үүргийг дагнан хэрэгжүүлдэг байгууллагын үндсэн бүтэц, орон тоонд багтсан, мэргэжлийн хяналтын байгууллагын нэгдмэл, төвлөрсөн удирдлагаас томилж чөлөөлдөг, уг байгууллагаас цалин, хөлс авдаг, **“Улсын байцаагч”** нэршилтэй төрийн захиргааны албан тушаал нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолд заасны дагуу дэс түшмэлийн ангилал, ТЗ-6 зэрэглэлд байна.

Хоёр. Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн ТЗ-6 ангилал зэрэглэлээр цалинжих болсон тухай;

1/ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Мэргэжлийн хяналтын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай, мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын алба, сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас бүрдэх тогтолцоотой байхаар заасан. Гэвч сумын түвшинд мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг дагнан хэрэгжүүлэх батлагдсан орон тоогүй байна.

2/ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд **“хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд Улсын байцаагчийн эрх олгож, хяналтын чиг үүрэг гүйцэтгүүлж болно”** гэж заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнд **“Улсын байцаагч”-ийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлэх**

замаар мэргэжлийн хяналтын болон орон нутгийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлж иржээ.

3/ Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн”-д үндсэн албан тушаалынх зэрэгцээ байгаль орчны хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх “Улсын байцаагчийн”¹ “тодорхой бүрэн эрх”² олгодог. “Сумын байгаль орчны мэргэжилтэн”-ийг мэргэжлийн хяналтын байгууллагын орон тооны Улсын байцаагчийн нэгэн адил ТЗ-6 ангилал, зэрэглэлээр цалинжуулах чиглэл өгөөгүй” гэсэн тайлбарыг өгсөн болно.

4/ Дээрх байдлаас харахад сумын Засаг даргын тамгын бүтэц, орон тоонд багтдаг, тус газраас томилогддог “Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалын ангилал, зэрэглэлийг мэргэжлийн хяналтын чиг үүргийг дагнан хэрэгжүүлдэг нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байгууллагын “Улсын байцаагч”-ийн албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адилтган үзэж цалин хөлс олгож ирсэн зөв биш жишиг тогтсон байна.

Гурав: Цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийн тухай;

1/ “Зөвшөөрөл олгох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 40 дүгээр тогтоол батлагдахаас өмнө сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орны асуудал хариуцсан мэргэжилтнээр хууль, журмын дагуу томилогдсон, Мэргэжлийн хяналтын зохих байгууллага, албан тушаалтнаас “Улсын байцаагч”-ийн эрх олгогдсон бол “Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 75 дугаар тогтоолыг баримтлан цалин хөлсийг бууруулахгүй байх;

2/ Сумын “Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн” албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд туслах түшмэлийн албан тушаалын ангилалд тавигдах тусгай шаардлагын дагуу сонгон шалгаруулалт явуулж нөхөх;

3/ Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэнд “Улсын байцаагч”-ийн эрх олгож хяналтын үүрэг гүйцэтгүүлэхдээ ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгох, цалингийн шатлал ахиулах, зэрэг дэвийг нэмэгдүүлэх, албан тушаалын ангилал, зэрэглэл шатлан дэвшүүлэх замаар хууль тогтоомжид нийцүүлэн цалин хөлс, нийгмийн баталгааг хангаж ажиллах нь зүйтэй.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**

¹ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10

² Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 4 дүгээр сарын 3 ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ /ТУХАЙН АЛБАН ТУШААЛЫН/ ШАЛГАЛТАД
ОРОЛЦОХ ИРГЭНИЙ БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

- 1.Төрийн албан хаагчийн анкет /"А", "Б" хэсэг/;
- 2.Тусгай шалгалтад бүртгүүлэх тухай бичгээр гаргасан хүсэлт;
- 3.Иргэний үнэмлэх;
- 4.Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/;
- 5.Нийгмийн даатгалын дэвтэр зэрэг хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нотлох баримт;
- 6."4 x 6" см хэмжээтэй цээж зураг;
- 7.Шаардлагатай бол мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт;
- 8.Төрийн албан хаагчийн хувьд үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн сүүлийн гурван удаагийн үнэлгээний баримт;
- 9.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох нотлох баримт.

Тайлбар:

- 1.Дээр дурдсан баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг заавал шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг иргэн хариуцна.
- 2.Хэрвээ хуурамч баримт бичиг бүрдүүлэн төрийн албаны тусгай шалгалтад бүртгүүлсэн, оролцсон, нэр дэвшсэн, албан тушаалд томилогдсон нөхцөлд үүнээс үүдэн гарах хариуцлагыг буруутай этгээд хүлээнэ.
- 3.Баримт бичгийн эх хувийг зохих шаардлагад нийцүүлэн цахим хэлбэрээр, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.
- 4.Төрийн албан хаагчийн анкет, шалгалтад бүртгүүлэх тухай хүсэлтэд өөрийн гарын үсгээ зурсан байна.